



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/48


Баян-Адарга сум

**Түр кемп байгуулах зөвшөөрөл
олгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хэнтий аймгийн Баян-Адарга сумын төвийн 2.82 км хатуу хучилттай авто зам гүйцэтгэгч Их хайрхны харгуй ХХК-д Дуурлиг багийн нутагт түр кемп байгуулж ажиллахыг зөвшөөрсүгэй.
2. Түр кемп байгуулах газрын байршлын солбицол, зургийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх газарт үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэлгүй холбогдох хууль тогтоомж болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллаж, ашиглаж дууссаны дараа зохих стандарт шаардлагын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай сайн гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгөхийг Их хайрхны харгуй ХХК-д даалгасугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дуурлиг багийн Засаг дарга (М.Нямдорж), Байгаль хамгаалагч (О.Батсуурь) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ОЛХАГВАДОРЖ

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг
даргын 2025 оны 02 дугаар сарын 15 ны
өдрийн А/18 тоот захирамжийн хавсралт



Түр кэмп байгуулах цэгийн солбицол, байршлын зураг

№	Газрын зориулалт	Солбицол		Талбайн хэмжээ
		N	E	
1	Түр кэмп байгуулах	48.551607	111.384889	500мкв